

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Техникийн тодорхойлолт	Үлдэгдэл /тоо ширхэг/
	Загийн усны хоолойн гүний усны ордоос Тавантолгой нүүрсний уурхай хүртэл ус татах шугам хоолойн барилга усралтын ажлын гүйцэтгэх ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээ		1		<i>хавсралтаар</i>	

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Ажлын даалгавар боловсруулах үндэслэл

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн ирээдүйн болон алс хэтийн төлөв, хөгжлийн стратегийн бодлогод томоохон ач холбогдол бүхий говийн бүсэд орших эрчим хүчний зориулалттай болон коксжсон нүүрсний уурхайнуудын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэснээр тус бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг онцор түвшинд хүргэх боломжийг бүрдүүлж байна. Стратегийн хөгжлийн онц чухал зорилтыг хэрэгжүүлэх шатанд нэн тэргүүнд шинээр барьж байгуулахаар төлөвлөж буй нүүрс баяжуулах үйлдвэрийн цогцолборын ус хангамжийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх шаардлагатай

Тус шаардлагын хүрээнд 2015-2016 онд Өмнөговь аймгийн Цогт-цэций сумын нутагт орших “Загийн усны хоолой” газрын доорх усны ордод гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийгдэж усны нөөцийг үйлдвэрлэлийн зохих зэрэглэлийн түвшинд үнэлж тодорхойлсон байна. Иймд тус усны нөөцийг ашиглах, Тавантолгойн ордыг түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрт хэрэглэх, түүнтэй холбоотой ус хангамжийн системийн иж бүрэн ажлыг хийх шаардлага гарч ирээд байна. Уг ажлын даалгавар нь ус хангамжийн системийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг амжилттай хэрэгжүүлж дуусгах үндэс суурь болно гэж үзэж байна.

1.2. Төсөлд хамрагдах бүс

“Загийн усны хоолой” газрын доорх усны орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт төв Азийн гадагш урсгалгүй ай савд байрлах бөгөөд ус хангамжийн систем нь 14 ш гүний худаг- 30км урт ус цуглуулах хоолой-2 ш өргөлтийн насос станц- 61,6 км урттай гол шугам хоолойгоор 63,65л/с усыг Тавантолгой нүүрсний уурхай хүртэл дамжуулан ашиглах юм.

1.3. Төслийн зорилго, чиглэл

Ус хангамжийн төслийн зорилго нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Загийн усны хоолой” газрын доорх усны ордоос шугам хоолой татах ус хангамжийн системийн барилга угсралтын ажлыг дуусгаж Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн баригдах нүүрс баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээг хангахад оршино.

2. АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ

Ус хангамжийн системийн барилга угсралтын ажлын даалгаварт Загийн усны хоолойн Тавантолгой нүүрсний уурхай хүртэлх шугам хоолойн дараах барилга байгууламжийг хамруулна. Үүнд:

1. Ашиглалтын худгууд
2. Ус цуглуулах шугам
3. Усан сан
4. Өргөлтийн насос станцууд
5. Ус дамжуулах гол шугам
6. Хиймэл нуур
7. Ундны усны цэвэршүүлэх байгууламж
8. Дэд бүтцийн байгууламжууд (автозам, цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам, шилэн кабелийн шугамуудын байрлал г.м)

3. БАТАЛГААЖУУЛАЛТ

3.1. Ажлын даалгаврыг боловсруулахдаа "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам хоолой татах төслийн Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр баталгаажсан зураг төслийг үндэс болгоно.

3.2. Ажлын даалгаврыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД стандартын дагүү хийж гүйцэтгэх.

3.3. Боловсруулсан ажлын даалгаврыг захиалагчийн төлөөлөгчөөр хянуулж баталгаажуулна

4. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛЛАГА

Усны мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага байна.